# ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Говьсүмбэр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ГСА-2024/09НА-СТА-ТШЗ


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Говьсүмбэр аймаг<br>2024 он | Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа<br>Утас: 70543179<br>Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn<br>Аудитын менежер: Г.Наранбаяр<br>Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn<br>Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн:<br>Баталгаат тооцоолол аудитХХК-ийн<br>Захирал: М.Буянбулган<br>Утас: 77153069<br>Цахим хаяг: buyanbulgan@batalgaattaudit.com<br>Чанарын менежер: Г.Цогтбаатар<br>Аудитор: Н.Цэнгэнбаяр |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

**Нэг.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**

**Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**.................4

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан....................................................4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ................................................4

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.......................................................6

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..........................7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан...................................................8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан......................................9

**Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**..........................................................................10

**5.1 Албан шаардлага**.........................................................................................**10**

5.1.1 Цалингийн зардалтай холбоотой асуудал ...................................................10

**5.2 Зөвлөмж**.......................................................................................................**11**

**Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**......................12

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**......................................................12

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ГСА | Говьсүмбэр аймаг |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| МУЕА | Монгол улсын ерөнхий аудитор |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ХХААГ | Хүнс, хөдөө аж ахуйн газар |
| ХХААЯ | Хүнс, хөдөө аж ахуйн яам |

## Нэг.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс:976-7054 3179
И-мэйл: govisumber@audit.gov.mn

2024.02.23 № 36

танай ____________-ны № ______________-т

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ Э.ТҮВШИНЗАЯА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

008020288

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тайлант онд 25 зорилтын хүрээнд 66 арга хэмжээг хэрэгжүүлж 92.8 хувиар гүйцэтгэсэн гэж тайлагнасныг аймгийн Засаг дарга 88.7 хувийн биелэлттэй дүгнэсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.САРАНТУЯА

# Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

*/Төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **46,329,689.25** | **74,693,682.80** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 7,144,806.00 | 12,196,398.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **7,144,806.00** | **12,196,398.00** |
| 31217 | Нөөц харилцах ахмад | 7,144,806.00 | 12,196,398.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **39,184,883.25** | **62,497,284.80** |
| **351** | **Түүхий эд материал** | **3,182,500.00** | **22,516,500.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 3,182,500.00 | 22,516,500.00 |
| **354** | **Хангамжийн материал** | **15,997,383.25** | **19,975,784.80** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,294,427.00 | 2,627,495.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,312,744.00 | 6,462,121.05 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 13,390,212.25 | 2,886,168.75 |
| 35600 | Мал амьтад | 0.00 | 8,000,000.00 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | **20,005,000.00** | **20,005,000.00** |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **361,589,373.78** | **412,921,954.50** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 361,589,373.78 | 412,921,954.50 |
| **392** | **Биет хөрөнгө** | **246,337,704.63** | **299,074,452.03** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 249,617,547.00 | 249,617,547.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (86,450,484.54) | (98,405,848.98) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 69,849,280.00 | 69,849,280.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (39,640,946.74) | (54,140,946.82) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 70,799,701.77 | 74,325,101.77 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (28,123,298.64) | (45,634,142.64) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 11,045,925.00 | 14,064,263.40 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (6,647,750.68) | (10,251,879.04) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 15,698,820.00 | 115,759,820.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (9,811,088.54) | (16,108,742.66) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **115,251,669.15** | **113,847,502.47** |
| 39301 | Програм хангамж | 7,892,500.00 | 7,892,500.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (5,122,152.85) | (6,526,319.53) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 112,481,322.00 | 112,481,322.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **407,919,063.03** | **487,615,637.30** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | 407,919,063.03 | 487,615,637.30 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 437,896,678.25 | 437,896,678.25 |
| | Дахин үнэлгээний нөөц | 83,782,795.68 | 83,782,795.68 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **(113,760,410.90)** | **(34,063,836.63)** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (113,760,410.90) | (116,354,674.10) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 82,290,837.47 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **407,919,063.03** | **487,615,637.30** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

*/Төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **277,330,069.75** | **630,167,866.00** |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **43,370,269.75** | **180,382,956.00** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,228,100.00 | 9,264,000.00 |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 22,274,400.00 | 100,771,000.00 |
| 1200018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа материал | 15,867,769.75 | 70,347,956.00 |
| **1311** | **Тусламж, санхүүжилтийн орлого** | **21,536,000.00** | **7,285,376.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 4,647,076.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,500,000.00 | 1,738,300.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 432,000.00 | 900,000.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлэгээс манхүүжих | 17,604,000.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **0.00** | **6,439,134.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 0.00 | 6,439,134.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | **212,423,800.00** | **436,060,400.00** |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 212,423,800.00 | 436,060,400.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **284,750,764.26** | **511,135,306.93** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **284,750,764.26** | **511,135,306.93** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 186,788,211.46 | 280,065,941.00 |
| 210101 | Үндсэн цалин | 133,880,125.18 | 169,129,288.00 |
| 210102 | Нэмэгдэл | 31,996,028.16 | 64,483,469.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 14,988,800.12 | 32,845,293.00 |
| 210104 | Урамшуулал | 5,923,258.00 | 13,607,891.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **22,907,936.50** | **33,538,407.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,840,147.78 | 23,854,683.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,866,368.15 | 2,741,280.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,472,934.29 | 2,127,024.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 338,953.31 | 689,601.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,389,532.97 | 4,125,819.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **7,184,574.46** | **8,226,926.44** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 857,926.46 | 1,009,729.44 |
| 210302 | Түлш, халаалт | 5,632,098.00 | 6,570,738.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 694,550.00 | 646,459.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **9,938,714.00** | **27,157,469.65** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,141,740.00 | 1,840,332.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,204,660.00 | 14,591,544.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,029,991.00 | 945,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 216,000.00 | 156,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 34,500.00 | 150,593.35 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 2,311,823.00 | 0.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 0.00 | 9,473,800.30 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **708,600.00** | **20,950,900.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 218,000.00 | 299,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 490,600.00 | 20,651,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **2,611,160.00** | **10,158,400.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,611,160.00 | 10,158,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **8,999,635.00** | **23,891,280.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 248,680.00 | 17,208,739.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 1,080,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 456,655.00 | 274,725.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 294,200.00 | 393,200.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 110,000.00 | 77,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,740,000.00 | 4,740,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 150,100.00 | 117,616.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **41,779,337.26** | **61,068,007.28** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,380,003.00 | 10,269,608.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 40,399,334.26 | 50,798,399.28 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,000,000.00** | **900,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 900,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **2,832,595.58** | **45,177,975.56** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,832,595.58 | 45,177,975.56 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(7,420,694.51)** | **119,032,559.07** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **13,437,196.00** | **36,741,721.60** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 1,261,260.00 | 0.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 12,175,936.00 | 36,741,721.60 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **(20,857,890.51)** | **82,290,837.47** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(20,857,890.51)** | **82,290,837.47** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

*/Төгрөгөөр/*

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх он** | **Тайлант он** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **239,977,290.00** | **464,626,470.00** |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **5,228,100.00** | **9,264,000.00** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,228,100.00 | 9,264,000.00 |
| **1311** | **Тусламж, санхүүжилтийн орлого** | 22,325,390.00 | 12,824,510.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 4,647,076.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,500,000.00 | 1,738,300.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,221,390.00 | 6,439,134.00 |
| 131107 | Тумгай зориулалтын шилжүүлэгээс санхүүжих | 17,604,000.00 | 0.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 0.00 | 6,477,560.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 0.00 | 6,477,560.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 212,423,800.00 | 436,060,400.00 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 212,423,800.00 | 436,060,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **236,642,290.00** | **459,574,878.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **236,642,290.00** | **459,574,878.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 186,924,547.96 | 280,065,941.00 |
| 210101 | Үндсэн цалин | 132,959,320.05 | 185,259,052.00 |
| 210102 | Нэмэгдэл | 31,761,252.03 | 65,837,774.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 15,285,975.91 | 15,540,458.00 |
| 210104 | Урамшуулал | 6,917,999.97 | 13,428,657.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **22,771,600.00** | **33,538,407.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,641,601.00 | 23,854,683.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,843,244.00 | 2,741,280.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,470,835.00 | 2,127,024.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 346,856.00 | 437,765.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,469,064.00 | 4,377,655.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **7,184,574.46** | **8,226,926.44** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 857,926.46 | 1,009,729.44 |
| 210302 | Түлш, халаалт | 5,632,098.00 | 6,681,267.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 694,550.00 | 535,930.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **5,227,191.00** | **10,313,634.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 575,100.00 | 1,895,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,200,600.00 | 7,116,034.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,029,991.00 | 945,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 216,000.00 | 156,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 205,500.00 | 200,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,765,100.00** | **22,679,700.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 975,000.00 | 477,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 790,100.00 | 22,201,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **2,611,160.00** | **5,048,400.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,611,160.00 | 5,048,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **3,408,655.00** | **44,297,086.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,857,700.00 | 37,926,261.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0.00 | 770,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 456,655.00 | 274,725.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 294,200.00 | 393,200.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 110,000.00 | 77,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 540,000.00 | 4,739,200.00 |
| 210807 | Газрын төлбөр | 150,100.00 | 116,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **2,916,866.00** | **9,326,808.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,916,866.00 | 9,326,808.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,000,000.00** | **900,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 900,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **2,832,595.58** | **45,177,975.56** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,832,595.58 | 45,177,975.56 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **800,000.00** | 0.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 800,000.00 | 0.00 |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 2,535,000.00 | 5,013,166.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 4,609,806.00 | 7,144,806.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 7,144,806.00 | 12,196,398.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

*/Төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **437,896,678.25** | **83,782,795.68** | **(113,760,410.90)** | **407,919,063.03** |
| D01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **437,896,678.25** | **83,782,795.68** | **(113,760,410.90)** | **407,919,063.03** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | (2,594,263.20) | **(2,594,263.20)** |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **437,896,678.25** | **83,782,795.68** | **(116,354,674.10)** | **405,324,799.83** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 82,290,837.47 | **82,290,837.47** |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **437,896,678.25** | **83,782,795.68** | **(34,063,836.63)** | **487,615,637.30** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

*/Төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь |
|---|---|---|---|---|
| **11000** | **Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл** | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **436,060,400.00** | **396,459,984.44** | **90.9** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **435,066,100.00** | **395,559,984.44** | **90.9** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **308,825,800.00** | **275,547,771.00** | **89.2** |
| 210101 | Үндсэн цалин | 195,223,600.00 | 185,259,052.00 | 94.9 |
| 210102 | Нэмэгдэл | 80,075,800.00 | 61,319,604.00 | 76.6 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 16,226,000.00 | 15,540,458.00 | 95.8 |
| 210104 | Урамшуулал | 17,300,400.00 | 13,428,657.00 | 77.6 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **38,602,800.00** | **32,984,601.00** | **85.4** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,250,100.00 | 23,300,877.00 | 88.8 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,088,300.00 | 2,741,280.00 | 88.8 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,470,500.00 | 2,127,024.00 | 86.1 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 617,600.00 | 437,765.00 | 70.9 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,176,300.00 | 4,377,655.00 | 70.9 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **8,724,700.00** | **8,226,926.44** | **94.3** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,107,600.00 | 1,009,729.44 | 91.2 |
| 210302 | Түлш, халаалт | 6,807,100.00 | 6,681,267.00 | 98.2 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 810,000.00 | 535,930.00 | 66.2 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **6,740,700.00** | **6,740,700.00** | **100.0** |
| 210401 | Бичиг хэрэг | 815,700.00 | 815,700.00 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,623,100.00 | 4,623,100.00 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 945,200.00 | 945,200.00 | 100.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 156,000.00 | 156,000.00 | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 200,700.00 | 200,700.00 | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **22,679,700.00** | **22,679,700.00** | **100.0** |
| 210601 | Багаж, техник хэрэгсэл | 477,800.00 | 477,800.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 22,201,900.00 | 22,201,900.00 | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **4,572,000.00** | **4,460,000.00** | **97.6** |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,572,000.00 | 4,460,000.00 | 97.6 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж** | **44,297,200.00** | **44,297,086.00** | **100.0** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 37,926,300.00 | 37,926,261.00 | **100.0** |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 770,000.00 | 770,000.00 | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 274,800.00 | 274,725.00 | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 393,200.00 | 393,200.00 | 100.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 77,000.00 | 77,000.00 | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,739,200.00 | 4,739,200.00 | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 116,700.00 | 116,700.00 | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **623,200.00** | **623,200.00** | **100.0** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 623,200.00 | 623,200.00 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **994,300.00** | **900,000.00** | **90.5** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 994,300.00 | 900,000.00 | 90.5 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | **436,060,400.00** | **436,060,400.00** | **100.0** |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 436,060,400.00 | 436,060,400.00 | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

*/Төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)** | **13,724,510.00** |
| **210** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **13,724,510.00** |
| **2101** | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **4,518,170.00** |
| 210102 | Нэмэгдэл | 4,518,170.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **553,806.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 553,806.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **3,572,934.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,080,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,492,934.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **588,400.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 588,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **4,491,200.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,491,200.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)** | **19,302,070.00** |
| **1310** | **Улсын төсвөөс** | **6,439,134.00** |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 6,439,134.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **12,862,936.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан | 4,647,076.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | 1,738,300.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 6,477,560.00 |

## Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 36,523.5 мянган төгрөгийн алдаа[1] илэрсэн бөгөөд аудитын явцад залруулсан. Тухайлбал:

1. Завсрын аудитаар 36,523.5 мянган төгрөгийн бараа материалыг зохих ангиллын дагуу зөв бүртгэж тайлагнаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө:", 4.1.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт;", 5.1.4 дэх "үнэн зөв байх;", 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна.", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20.2.3-т " Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах; заалтуудыг зөрчсөн нь ангилал батламж мэдэгдлийг хангахгүй.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>:* Залруулга хийсэн

Аудитаар нийт 6,666.7 мянган төгрөгийн 3 зөрчил[2] илэрсэн бөгөөд уг зөрчилд алдааг дахин давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн.

### 5.1 Албан шаардлага

#### 5.1.1 Цалингийн зардалтай холбоотой асуудал

*<u>Илрүүлэлт:</u>* Тус газрын дарга бүтэц, орон тоогоор батлагдсан сул мэргэжилтний албан тушаалыг хавсран ажиллуулахаар албаны дарга А.Баярмаа 2022 оны Б/27, П.Дэлгэрмаа 2023 оны Б/19 тушаал гаргаж энэ онд нийтдээ 6,666,743.00 (Зургаан сая зургаан зуун жаран зургаан мянга долоон зуун дөчин гурван) төгрөгийн цалин тооцож олгосон.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно” Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 43.3.3-т: Энэ хуулийн 43.3.1, 43.3.2-т зааснаас бусад тохиолдолд албан тушаалтны албан үүргийг тухайн төрлийн албан тушаалын чиг үүрэгт нь хамгийн ойр хамааралтай албан хаагчтай тохиролцсоны дагуу түр орлон гүйцэтгүүлэх, 43.3.4-т ... албан тушаалын чиг үүрэг нь хамгийн ойр хамааралтай албан хаагчаар, эсхүл төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн иргэнийг сонгон авч, тодорхой хугацаагаар түр орлон гүйцэтгүүлэх, 43.6-т Энэ хуульд заасан журмыг зөрчиж, төрийн албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхийг хориглоно." заалтуудыг мөрдлөг болгоогүй нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>:* Сул орон тоог нөхөн, албаны даргад шууд харъяалагдах доод шатны албан тушаалыг хавсран гүйцэтгүүлсэн зөрчлийг арилгах

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 5.2 Зөвлөмж

1. Дотоод хяналт холбоотой асуудал

*<u>Илрүүлэлт:</u>* Анхан шатны бүртгэл хөтлөлтийг шалгахад жолоочийн тооцооны хүснэгтийн явсан замын бичвэр ерөнхий, цалингийн тооцооны хүснэгтийн тэмдэглээ, баталгаажуулалт, баримтын бүрдэл дутуу байсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." заалт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан журмын тухайн маягтуудыг хөтлөх, гүйцэтгэлд хяналт тавих зааварыг мөрдлөг болгоогүйтэй холбоотой байгаа нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Өгсөн зөвлөмж:</u> Агуулахын бүртгэл, жолоочийн тооцооны хуудас, анхан шатны баримтыг зааврын дагуу хөтлөх, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах

2. Бусад эрх зүйн акттай холбоотой асуудал

*<u>Илрүүлэлт:</u>*

Албан ажлын хэрэгцээнд ашиглаж буй автомашины улсын бүртгэлийн дугаарын дэвсгэрийн өнгө солиогүй.

Энэ нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/140 дугаар тушаалаар баталсан "Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-ын 12.3-т "Автотээврийн хэрэгслийг төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд ашиглаж эхлэх болон хасагдах тохиолдолд эрх бүхий байгууллагын тодорхойлолтыг үндэслэн улсын бүртгэлийн дугаарын сери болон тоог өөрчлөхгүйгээр зөвхөн дэвсгэр өнгийг өөрчлөн сольж олгоно.", 14.4.-т "Энэхүү журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ." заалтуудыг мөрдлөг болгоогүй нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Өгсөн зөвлөмж:</u> Албан ажлын автомашины улсын дугаарын өнгө солих

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

# Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Залруулга | 1 | 36,523.5 | | | 1 | 36,523.5 | 1 | 36,523.5 | | | 1 | 36,523.5 |
| Дүн | 1 | 36,523.5 | | | 1 | 36,523.5 | 1 | 36,523.5 | | | 1 | 36,523.5 |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Цалингийн зардал | 1 | 6,666.7 | - | - | 1 | 6,666.7 | - | - | - | - | - | - |
| **Дүн** | 1 | 6,666.7 | - | - | 1 | 6,666.7 | - | - | - | - | - | - |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой | 1 | 0.0 | - | - | - | - | 1 | 0.0 |
| Анхан шатны баримттай холбоотой | 1 | 0.0 | - | - | - | - | 1 | 0.0 |
| Дүн | 2 | 0.0 | - | - | - | - | 2 | 0.0 |

# Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |